

ТЭРГҮҮН

**ЭНХ ТАЙВАН
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ ПРОГРАММ**

Олон улсын коммунист хөдөлгөөний салшгүй хэсэг ЗХУКН-ын ХХVI их хурлаас дэвшүүлсэн «Олон улсын аюулгүй байдлын бүх талыг хамарсан систем бий болгох» тухай санал санаачлага ХХ зууны сүүлчийн 15 жилийн дэлхийн улс төрийн бодлогод эрс эргэлт гаргах эх суурь тавилаа. ЗХУКН орчин үеийн дэлхий ертөнц, түүний үндсэн хандлага болон зөрцөлд марксист диалектик сургаалын үндсэн дээр гүн гүнзгий задлан шинжилгээ хийж бүх талаар дүгнээд олон улсын харилцааны туйлын хурцадмал өнөөгийн нөхцөлд социалист, социалист бус хоёр ертөнц энх тайвнаар зэрэгцэн орших ленинч зарчмыг хэрэгжүүлэхээс өөр ямарч сонголт байхгүй гэдгийг тодорхойллоо.

ХХVI их хурлаараа нэмж засварлан баталсан ЗХУКН-ын программд энэ зарчмыг бат тууштай хамгаалах тухай зааснаар барахгүй энх тайвнаар зэрэгцэн орших бодлогын агуулгыг улам тодруулж, бүтээлчээр баяжууллаа. Ийм учраас ЗХУКН-ын программ бол хамарсан асуудлын цар хүрээ, бодит агуулгаараа эрин үеийн хамгийн гол гогцоо асуудал болсон энх тайван, аюулгүй байдлыг хангах программ, ЗСБНХУ-ын энх тайванч тууштай бодлогын тод илрэл юм.

ХХVII их хуралд оруулсан ЗХУКН-ын Төв Хорооны улс төрийн илтгэлд (... хоёр систем энх тайвнаар зэрэгцэн орших нь улс хоорондын харилцааны хууль болох ёстой» гэж М. С. Горбачев шууд цохон тэмдэгдлээ. Энэ бол ЗСБНХУ-ын болон ЗХУКН-ын энх тайванч гадаад бодлогын стратегийн залгамж чанар мөн. Ийм гарцаагүй шаардлага орчин үеийн олон улсын харилцааны бодит амьдралаас урган гарч байгаа нь илэрхий билээ.

Өнөө үед АНУ тэргүүтэй империалист бүлгийнхэн «Оддын дайнд» зориулж шинэ шинэ цогцолбор боловсруулан туршиж, тэрч байтугай хоёр ертөнцийн цэрэг стратегийн тэнцвэртэй байдлыг алдагдуулах зорилгоор социализмын ертөнцийн эсрэг технологийн дайн хийж байна. Цөмийн дайн дэгдээх нь хүн төрөлхтний эсрэг хамгийн хүнд гэмт хэрэг юм. Ийм ч болохоор ЗХУКН дэвшүүлсэн зорилтдоо үнэнч байж уг зорилгоо шийдэмгий хэрэгжүүлэхийн төлөө өөрөөсөө шалтгаалах бүхнийг хийж байгаа билээ. Энэ талаар цөмийн зэвсгийг эргэлт буцалтгүй устгахыг эрин үе, амьдрал шаардаж байгаа тухай Аргентин, Энэтхэг, Мексик, Танзани, Швед, Грекийн удирдагчдын хамтарсан илгээлт бичигт ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачевын явуулсан хариу илгээлт ч гэрчилсэн юм.

Тоо бүртгэлийн мэдээгээр 1980 онд дэлхийн хэмжээгээр цэрэг дайны байдалд минут дутам сая шахам доллар зарцуулагдсан байна. Гэтэл дэлхийн хүн амын дөрөвний нэг буюу миллиард гаруй хүн өвчин зовлон, өлсгөлөн, гуйланчлалд нэрвэгдсээр байна. Хэрвээ дэлхийн бүх улсын цэрэг дайны зардлын ганц жилийн төсөв буюу 500 миллиард гаруй долларыг хүний төлөө зарцуулбал олон зуун сая хүнийг өвчин эмгэг, өлбөрөл хоосролоос ангижруулж чадах билээ.

ЗХУКН, ЗСБНХУ ХХ зууны эцэст үйлдвэрлэлийн потенциал 2 дахин нэмэгдүүлэх аварга том зорилт дэвшүүлэн тавьж байна. Хэрэв

дэлхийн II дайнд 4 жил алдаагүй бол ийм зорилт өнөөдөр ч биелэгдсэн байж болох сан. Ийм учраас дайны аюулыг эсэргүүцэж энх тайвныг эрхэмлэх нь социалист нийгмийн мөн чанараас үүдэн гардаг зорилт юм.

Цөмийн зэвсгийн нөөц хуримтлагдах тусам дайны аюул осол нэмэгдэж, цөмийн зэвсэгтэй улс орон ч олшрох уршигтай. XX зууны эцсээр Пакистан, Иран, Ливи, Өмнөд Солонгос, ХБНГУ, Япон, Израиль, ӨАБНУ, Бразиль, Аргентин улсууд цөмийн зэвсэгтэй гүрэн болж хувирах боломжтой гэж Америкийн мэргэжилтнүүд тооцоолжээ.

Ийм нөхцөлд ЗХУКН Цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах шинэ өргөн далайцтай санал, санаачлага гаргаад зогсоогүй, түүнийг хэрэгжүүлэх бодит арга замыг туурвиж, өөрөө түрүүлж үлгэр жишээ үзүүлж зэвсэг хураах тэмцэлд хошуучилж байна. Ийм арга хэмжээнд XXVII их хурлын босгон дээр болон хурлын дараа ч дэвшүүлж байгаа алсын хараат чухал саналууд зүйн ёсоор орох ёстой. М. С. Горбачев 1986 оны 1-р сарын 15-нд хийсэн мэдэгдэлдээ цөмийн туршилтыг азнаж, улмаар цөмийн болон үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсгийг гурван шаттайгаар устгаж XXI зуунд хүн төрөлхтөн хүнийг үй олноор нь устгах хөнөөлт зэвсэггүй шилжин орох санал дэвшүүлсэн бол Зөвлөлт, Америкийн Женевийн дээд хэмжээний уулзалтын үр дүнг тасалдуулахгүй, харин нэгэнт эхэлсэн нааштай яриа хэлэлцээгээ үргэлжлүүлж анхны том алхам хийх асуудлаар тохиролцож зохих хэлэлцээр байгуулах зорилгоор дараагийн уулзалтыг Лондон, Рим зэрэг Европын аль ч орны нийслэлд яаралтай эхлэхэд бэлэн байгаагаа илэрхийллээ. 3-р сарын 29-нд М. С. Горбачев Зөвлөлтийн телевизээр хийсэн энэ шинэ мэдэгдэл нь Рейганы засаг захиргаа хэдийгээр цөмийн дэлбэрэлтээ үргэлжлүүлж өдөөн хатгасаар байгаа боловч ЗХУ цөмийн туршилтыг хориглох асуудалд аль зэрэг тууштай тэвчээртэй хандаж, нөгөө талаар АНУ-д бодлогоо эргэж харах бололцоо олгож буйг харуулж байна.

Цөмийн дайныг дэгдээх ёсгүй гэж заасан Зөвлөлт, Америкийн Женевийн уулзалтыг манай нам, ард түмэн «Эцсийн эцэст саруул ухаан ялан мандахын тодорхой найдлага төрүүлсэн дэлхий дахины ач холбогдолтой томоохон үйл явдал боллоо» гэж (1985 оны 12-р сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны XI бүгд хурал) үзсэн билээ.

Эрдэмтэдийн тооцоолсоноор, хэрэв цөмийн дайн үүсвэл хэдэн зуун сая хүний амь үрэгдэж, үзэгдээгүй их эвдрэл сүйрэл учирна гэж 10-15 жилийн өмнө ярьдаг байсан бол одоо тийм дайны уршгаар хүн, барилга байгууламж төдийгүй хүрээлэн буй орчин хэлмэгдэн сүйрч улмаар хүн төрөлхтний соёл иргэншил мөхөх аюулд хүрч болох нь нотлогдож байна.

ЗХУКН-ын XXVI их хуралд оролцсон МАХН-ын төлөөлөгчдийн тэргүүн н, Ж. Батмөнх тус их хурал дээр хэлсэн үгэндээ: «Газар дэлхийд нөр хичээнгүй хүч хөдөлмөрөөрөө хосгүй соёл иргэншил бий болгож чадсан хүн ард, түүнийгээ хамгаалах ёстой. Хамгаалж ч чадна гэдэгт бид итгэдэг» гэж цохон тэмдэглээд дэлхийн хүн амын бараг гуравны хоёр нь оршин суугаа Ази тивийн хувьд бол түүний «найдвартай байдлыг хангах, милитаризм, түрэмгийллийн хүчийг давамгайлж байхын тулд хүч чармайлтаа нэгтгэх гэсэн ЗХУ, социалист бусад орон, түүнчлэн тус бүс нутгийн энхийг эрхэмлэгч улс гүрний оновчтой саналыг тууштай дэмжиж байна» гэж манай улсын байр суурийг тодорхойлсон юм. Ийм үзэл санааны үүднээс ЗХУКН-ын XXVII их хурлын дараахан манай улсад зохиогдсон нэг тэмдэглүүштэй арга хэмжээ бол Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд парламентын гүйцэтгэх үүргийн тухай зөвлөн хэлэлцсэн Азийн социалист орнуудын парламентын төлөөлөгчдийн Улаанбаатарын зөвлөлдөх уулзалт юм.

Уг уулзалтанд оролцсон БНСВУ, ЗСБНХУ, БНХАУ, БНАЛАУ, БНМАУ, БНАСАУ-ын парламентын төлөөлөгчид ЗХУКН-ын XXVII их хурлаас дэвшүүлсэн олон улсын аюулгүй байдлын бүх талыг хамарсан систем бий болгох үзэл санааг хэрэгжүүлэхэд Азийн орнуудын чуулга уулзалт хийх болон Ази тивийн аюулгүй байдалд иж бүрэн хандах тухай зэрэг саналуудыг оролцуулан Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн социалист болон бусад улсын гадаад бодлогын санаачлагуудыг хэрэгжүүлэх үйл хэрэгт парламентууд, парламентын гишүүдийн хамтын ажиллагааг улам идэвхжүүлэхийн чухлыг цохон тэмдэглэлээ. Тэд энэ зууны эцэс гэхэд цөмийн дайны аюулаас болон үй олноор устгах бүх төрлийн зэвсгээс хүн төрөлхтнийг ангижруулах, бүх улс, ард түмний оновчтой үр бүтээлтэй хамтран ажиллах урьдчилсан нөхцөлийг бүрэлдүүлэхэд чиглэсэн ЗХУ-ын саналыг өндөр үнэлж, санал нэгтэй дэмжлээ.

ЗХУКН-ын XXVII их хурал Ази, Номхон далайн чиглэлийн өсөн нэмэгдэж байгаа ач холбогдлыг тэмдэглэж Азийн янз бүрийн нутгийн эмзэг асуудлыг улс төрийн аргаар зохицуулахын тулд юуны өмнө ул суудын хүчин чармайлтыг зохицуулан нэгтгэх ажлаас эхлэх нь зүйтэй гэж үзлээ. ЗХУКН-ын ТХ-ны улс төрийн илтгэлд социалист ертөнцийн орнуудын нэгдэл нягтралыг онцгой анхаарч түүний дотор их хөрш социалист Хятад улстай ЗХУ-ын харилцах харилцаа тодорхой хэмжээгээр сайжирсныг сэтгэл хангамжтай тэмдэглээд цаашид ч гуравдах оронд хохирол учруулахгүйгээр харилцааг өргөтгөх боломж, хамтран ажиллах нөөц их байна гэж мэдэгдлээ. Өөрийн хоёр их хөрш Зөвлөлт, Хятадын харилцаа сайн байх явдал Монголын ард түмний язгуур эрх ашигт бүрэн нийцдэг бөгөөд Монгол, Хятадын ард түмний уламжлалт хэлхээ холбоог бие биеийн бүрэн эрх, тусгаар тогтнолыг хүндэтгэх үндсэн дээр хөгжүүлэх бодлогыг МАХН, БНМАУ-ын засгийн газар тууштай баримталсаар ирсэн бөгөөд баримталж ч байна.

БНМАУ, БНХАУ-ын хоорондын харилцаа Монгол, Хятадын ард түмний болон Азийн энх тайван, аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцэн хөгжинө гэж найдаж байгаагаа илэрхийлж БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж. Батмөнх, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Д. Содном нараас БНХАУ байгуулагдсаны 36 жилийн ойг тохиолдуулан БНХАУ-ын дарга Ли Сяньнянь, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жао Зыян нарт явуулсан цахилгаан утсандаа дурьдсан байна.

Ийм өндөр бөгөөд өөдрөг үзэл санааг МАХН-ын яруу алдарт XIX их хурал иш үндэс болгож БНХАУ-тай харилцах манай гадаад бодлогын зарчмыг бататган заалаа.

ЗХУКН-ын их хурлын түүхэн шийдвэрийг энх тайвныг эрхэмлэгч нийт улс түмэн, түүний дотор АНУ дахь энх тайвны талынхан талархан дэмжиж, Рейганы бодит бус бодлого, хариуцлагагүй шийдвэрийг зэмлэн буруушааж байна. Ялангуяа дэлхийн олон орны коммунист ажилч ны намууд, юуны өмнө социалист орны ах дүү намууд зөвлөлтийн саналыг өөрсдийн их хурлуудаар өргөн дэмжиж байна. Жишээ нь ЧКН-ын XVII их хурал ЗХУКН-ын XXVIII их хурлаас баталсан энх тайвны цогцолбор программыг хүн төрөлхтний өмнө хосгүй бололцоо нээж байна. Улс түмэн ирээдүйнхээ төлөө айх аюулгүйгээр XXI зуунтайгаа золгоё гэвэл энэ түүхэн бололцоог ашиглах ёстой гээд уг программыг ЧКН, чехословакийн бүх ард түмэн бүрэн дүүрэн дэмжиж байгаагаа илэрхийллээ.

ЗХУКН-ын XXVII их хуралд оролцсон МАХН-ын төлөөлөгчдийн тэргүүн МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга,

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж. Батмөнхийн мэдээллийг МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо сонсоод гаргасан тогтоолд Зөвлөлтийн коммунистуудын дээд чуулга нь орчин үеийн улс төрийн гайхамшигт үйл явдал болж, Марксизм, Ленинизмыг бүтээлчээр хөгжүүлэхэд асар их хувь нэмэр оруулсныг тэмдэглээд дэлхийн социализмын эрх ашгийн үүднээс Ази, Номхон далайн бүс нутгийн болон дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлын төлөө тэмцэлд хоёр орны хамтын ажиллагааг хойшид ч гүнзгийрүүлэх шийдвэр төгс байгаагаар илэрхийлсэн юм. Манай хоёр орны ард түмний уламжлалт найрамдал, нягт хамтын ажиллагаа энх тайван, социализмын үйл хэрэгт нийцэн жилээс жилд өрнөн хөгжиж хоёр ард түмний найрамдлын түүхийн алтан хуудсууд агуу их Октябриар эх суурь нь тавигдсан улс хоорондын шинэ маягийн харилцааны үлгэр дууриалал болсоор байна.

Энх тайван, социализмын үзэл санаа болох их Лениний үзэл санааг бүрэн илэрхийлсэн ЗХУКН-ын XXVI их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх дэс дараатай алхамыг ЗСБНХУ болон социалист бусад орнууд, тасралтгүй санаачилсаар байна. Энэ оны 5-р сард Будапешт хотноо болсон Варшавын гэрээнд оролцогч орнуудын улс төрийн зөвлөлдөх хоороны зөвлөлгөөнөөс Ази, Номхон далайн район, Африк, Латин Америкт энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, сайн хөршийн ба хамтын ажиллагааны харилцааг хөгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Олон улсын аюулгүй байдлын бүх талыг хамарсан систем бий болоход их лениний хэлсэнчлэн газар зүй, эдийн засаг түүхийн аль ч талаар зөвхөн европ төдийгүй бас Азид ч хамаарах Орос улс хийгээд, Ази Номхон далайн бүс нутгийн бусад улс орнууд хувь нэмэр оруулах нөхцөл болсон хэд хэдэн чухал шинэ санал санаачлага ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачевын саяхан Владивосток хотод хэлсэн үгэнд тусгалаа оллоо.

Ази, Номхон далайн районы энх тайван аюулгүй байдлыг бэхжүүлэхтэй холбогдсон энэхүү шинэ санал санаачлагыг дэлхийн дэвшилт олон нийт, түүний дотор Монголын ард түмэн баяртай хүлээн авч талархан дэмжиж байна. М. С. Горбачевын дэвшүүлсэн өргөн цар хүрээтэй саналууд нь бүс нутгийн орнуудын хооронд яриа хэлэлцээ, хамтын ажиллагаа явуулах, нийт Ази, Номхон далайн аюулгүй байдлыг хангах бодит замыг нээж буй хийгээд монголоос зөвлөлтийн цэргийн нэлээд хэсгийг гаргах асуудлыг Монгол, Зөвлөлтийн тал авч хэлэлцэж байгаа нь Ази тивд итгэлцэл, сайн хөршийн харилцааг бэхжүүлэхэд хувь нэмэр болж байна гэж БНМАУ-ын засгийн газрын 1986 оны 7-р сарын 31-ны мэдэгдэлд заан тэмдэглэлээ.

ЗХУ-ын шинэ санал санаачлага нь ЗХУКН-ын XXVII их хурлын энх тайванч түүхэн шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн Ази, Номхон далайн бүс нутгаар зогсохгүй олон улсын түгээмэл ач холбогдолтой чухал алхам болно.